

ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Дундговь аймаг: Орон нутгийн өмчийн газар

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
			2021 он	2022 он	2022	
1	Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан байдал	Хувь	100	100	2022 оны жилийн эцсийн байдлаар 51 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зарлан зохион байгуулаад байна.	100
2	ХАА-тай холбоотой гарсан гомдол саналын тоо	тоо	1	0	2022 оны жилийн эцсийн байдлаар 51 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарлан зохион байгуулж урилга болон үр дүнг tender.gov.mn, dundgovi.gov.mn, газрын пейж хуудсаар тухай бүр олон нийтэд хүргэн ажиллаж байна. 2022 оны тендер шалгаруулалтад тендерт оролцогчоос гомдол гараагүй байна.	100
3	Орон нутгийн төсөвт оруулах орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	100	100	Орон нутгийн өмчит 25 хуулийн этгээдийн 199 түрээсийн гэрээг баталгаажуулж, жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсөвт 19.5 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлээ. Мөн орон нутгийн өмчит байгууллагын акталсан хөрөнгө, барилга, их засвараас гарсан материалыг худалдан борлуулахад хяналт тавьж, жилийн эцсийн байдлаар орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 47.7 сая төгрөг төвлөрүүлээд байна. 2022 онд нийт орон нутгийн орлогын дансанд 53 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байгаагаас 67.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан бөгөөд орлого төвлөрүүлэлт 100 хувьтай байна.	100